



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
САЙНЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2021 оны 10 сарын 26 өдөр

Дугаар 01/177

Мандалговь

Газар эзэмшүүлэх тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3 "г", Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.3, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 03 тоот тогтоолоор баталсан "Газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөний тодотгол"-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын 4-р багийн иргэн Жаргалсайханы Рэнцэндагва (РД:3Ю86111176)-д хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн цогцолборын (тахианы аж ахуй) зориулалтаар 3-р багийн нутаг дэвсгэрт өвлийн нарлаг хүлэмжний зүүн талд байршилтай 4000 м.кв (0.4 га) газрыг 15 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

2. Газар эзэмшигчийн газрын гэрчилгээг олгож, газар эзэмших гэрээ байгуулж ажиллахыг газрын даамал (Л.Хулан), хяналт тавьж ажиллахыг Байгаль орчны хяналтын улсын байцаагч (Ж.Миеэсүрэн) нарт даалгасугай.

3. Эзэмшил газраа байгаль орчинд сөрөг нөлөөгүйгээр зориулалтын дагуу эзэмшиж, газрын төлбөрөө цаг тухайд нь төлж байхыг газар эзэмшигч (Ж.Рэнцэндагва)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



С.БАТ-ОРГИЛ